



СОЁЛЫН ЯАМ



**Г.ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ
ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙ**

**Г.ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ
ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙ
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2022 он

Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей нь Монголын дүрслэх урлагийн зуун зууны шилдэг зураач, урчуудын сор, дахин давтагдашгүй үзмэр цуглуулгыг дотоод, гадаадын үзэгчдэд дэлгэн толилуулж, эрдэм шинжилгээ судалгааны болон урлагийн гоо зүйн мэдлэг мэдээллээр хангах үүрэг бүхий нийгэмд чиглэсэн соёл, гэгээрэл, судалгаа, аялал-танин мэдэхгүй үйлчилгээ эрхэлдэг төрийн өмчит соёл, шинжлэх ухааны байгууллага юм.

Үндсэн чиглэл, үзэл баримтлалын хүрээнд соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжилж, нээн илрүүлэх, олж авах, үзмэрийг бүртгэн баримтжуулах, музейн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, үзүүлэлэг дэглэх, үйлчлэх, гадаад дотоодын үзэсгэлэн, боловсрол, танин мэдэхүйн ажил, сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, үзмэрийг гадаад, дотоод үзэсгэлэнд оролцуулах, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн соёлын дурсгалт зүйлийг түр хугацаагаар үзэсгэлэн, үзүүлэгт дэглэх ашиглах, музей хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

Тус музейн үзмэр цуглуулгын бодлого нь нэн эртний үеэс эхлэн XX зууны эхэн хүртэлх Монголын дүрслэх урлагийн түүхийг цогцоор нь илэрхийлсэн цуглуулгыг бүрдүүлж, олон нийтэд үзүүлж, гоо зүйн боловсролыг олгоход чиглэх бөгөөд сан хөмрөгт эртний урлагийн түүх, Өндөр гэгээн Г.Занабазар болон шилдэг зураач, урчуудын дахин давтагдашгүй сор бүтээлүүд, угсаатны зүйн, дүрслэх урлагийн төрөл зүйлийн бүтээлүүдээр баяжуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг хийж, бүртгэн баримтжуулж, хадгалан хамгаалж, сурталчлан таниулж, ард түмний өв соёлыг үеэс үед өвлүүлэн хадгалахад чиглэнэ.

Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей нь байнгын болон түр үзэсгэлэнгээр үзүүлэлэг дэглэлтэй зохион байгуулж олон нийтэд хүргэдэг.

Үйл ажиллагааны тайлан

Байнгын үзүүлэлэг дэглэлт нь Монголын эртний хадны сүг зураг, хүрэл зэвсгийн дурсгалууд, Монгол нутагт оршин тогтнож байсан эртний төрт улсууд Хүннү, Түрэг, Уйгар улсын түүх, археологийн дурсгалууд, Монголын уламжлалт ардын гар урлал, Өндөр гэгээн Г.Занабазар, түүний дэг сургууль болон шилдэг зураач, урчуудын бүтээлүүд, XVI-XX зууны эхэн үеийн дүрслэх урлагийн хосгүй үнэт бүтээлүүдээр төрөлжүүлэн биет үзмэрээр дэлгэн үзүүлэхийн зэрэгцээ орчин үеийн дижитал техник, технологийн нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн тусгай хэрэгцээтэй иргэд рүү чиглэсэн үзүүлэлэгийн хаяг тайлбар, үзмэр, эд зүйлийг биетээр хүрч мэдрэх боломжийг бүрдүүлэхийг зорин ажиллаж байгаа билээ.

Түр үзэсгэлэнгийн дэглэлт нь музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монголын болон гадаад урлагийн үзмэр цуглуулгыг эрдэм шинжилгээний үндэслэлтэй судалж, сэдэвчилсэн байдлаар цахим болон биетээр дэглэж, олон нийтэд хүртээмжтэй хүргэн, дижитал техник технологийн ашиглан тусгай үзэсгэлэнг бие даан болон иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулан ажилладаг.

Дүрслэх Урлагийн Музей нь 2022 онд сан хөмрөгөөс болон бусад хувь уран бүтээлчидтэй хамтран ажиллаж дотооддоо 34 удаагийн үзэсгэлэнг зохион байгуулж нийт танхимаар 10003 үзэгч, үйлчлүүлэгчдэд соёлын үйлчилгээгээр олон нийтэд үйлчлэв.


Нийт 34 үзэсгэлэн зохион байгуулсан /2022 он/



Үйл ажиллагааны тайлан

Музейн үзэсгэлэн болон бусад зохион байгуулсан арга хэмжээний мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудас, фэйсбүүк хуудаст байршуулж байна. Музейн байнгын үзүүллэгийн

танхим, түр үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулсан тусгай үзэсгэлэнгийн үзүүллэгээр үзэгч олон нийтэд үйлчилж, байнгын үзүүллэгийг 7214 үзэгч, тусгай үзэсгэлэнгээр 2789 үзэгчдэд үйлчлэв. Үзэгчдийг нас болон зорилтот бүлгээр ангилан үзвэл:



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТАЛААР

- Музейн боловсролын хөтөлбөрийг цахим болон танхимаар тогтмол хэрэгжүүлдэг. Үүнд:



- Музейн тайлбарт үйлчилгээг аудио төхөөрөмжөөр болон музейн тайлбарлагчаар тайлбарлуулж үзэгчдэд үйлчилсэн.
- Музейн байнгын үзүүллэгийн танхимуудад AR, VR технологийг үзүүллэгт ашиглан үзэгчдэд үйлчлэв.

СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Зорилт-1.4.1 ЭРДЭМ СУДЛАЛ-НИЙГМИЙН
СОЁН ГЭГЭЭРЭЛ

Эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэл:

- Т.Энхжаргал. Музейн үзэсгэлэнгийн тухай //музей мэдээ мэдээлэл сэтгүүл, Үндэсний музей. УБ.,2022
- Б.Оюунчимэг. Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй хүүхдийн хоёр дээлийн тухайд // Музей судлал. Үндэсний музей. УБ.,2022

Илтгэл хэлэлцүүлэг:

- Эрдэм шинжилгээний ажилтан Н.Саруул, Д.Гоомарал нар 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр “Рерих нар ба Монгол” V олон улсын хуралд “Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй Улаан хөлөгт баатар бүтээлийн тухай” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.
- Бүртгэл мэдээллийн санч Т.Энхжаргал, сан хөмрөгч Б.Оюунчимэг нар 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Зураг Нийгэмлэгийн 20 жилийн ойд зориулан зохион байгуулж буй “Монгол зураг судлал-уламжлал, шинэчлэл” эрдэм шинжилгээний хуралд “Монголын нэг өдөр зураг дах дүрслэлийн тоон дүнгийн судалгаа” илтгэл хэлэлцүүлэв.

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл: Үндэсний бахархал, эв нэгдэл 1.1.4. /Соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ/ зорилтын хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөн ажилласан:

- Хортон шавж, мэрэгч амьтнаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж музейн сан хөмрөгийн өрөөнүүд, албан хаагчийн ажлын өрөө болон танхимуудад халдваргүйжүүлэлт хийв.
- СӨҮТ-ийн заавар, зөвлөгөөний дагуу Сэргээн засварлагч үзмэрт цэвэрлэгээ, арчилгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.
- 2022 онд Соёлын өвийн бүртгэл программд үзмэрийн тодорхойлолтыг бичиж оруулсан байна.
- Музейн үзмэрт нэн шаардагдах “Органик хүчлийн хэмжилт судалгааны арга зүй” гарын авлага эх бэлтгэлийг хийж гарын авлага хэвлүүлэв.
- Органик хүчлийн хэмжилт судалгаа хийх ажлын хүрээн Органик хүчил, Аммиак, формальдегид гэсэн 3 төрлөөр хэмжилт хийж гүйцэтгэв.